



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Халамжийн сангийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/03/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Ховд хот

2023 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Аудитор: Ц.Гантулга

Утас: 99439613

Цахим хаяг: gantulgats@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

**ХӨДӨЛМӨР ХАЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ГАЗРЫН ДАРГА Л.БИЛЭГДЭМБЭРЭЛ
ТАНАА**

2023.02.02 № 2/07
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Халамжийн сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

2022 онд Нийгмийн халамжийн 62 нэр төрлийн үйлчилгээ цахимаар олгогддог болсноор үйлчлүүлэгч нар заавал биеэр очих шаардлагагүйгээр ehalamj.mn хаягаар үйлчилгээний хүсэлтээ илгээж халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт тусламжид хамрагдаж механик гар ажиллагааг хөнгөвчлөн цаасан материалын шаардлагагүй болсон бөгөөд хяналт шалгалтын ажлыг цахимаар хянах боломжийг бүрдүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж, хөнгөлөлт тусламжийн үйлчилгээнүүд цахимд шилжиж, Сангийн яамнаас иргэдийн нэрийн дансанд санхүүжилтүүдийг шууд хөрвүүлдэг болсноор өмнөх оны гүйцэтгэлээс тухайн оны гүйцэтгэл 98 орчим хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Х.БОЛДБААТАР

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	7
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	7
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	8
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	9
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	9
3.5.1 Төсвийн төлөвлөлт	9
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	9
3.5.3 Нэмэлт төсөв	9
3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн	9
4. АУДИТЫН ТАЙЛАН	10
4.1 Ерөнхий зүйл	10
4.2 Материаллаг байдал	10
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	10
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	10
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	10
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	11
4.5.1 Завсрын аудитын талаар	11
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	11
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	11
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	11
5.1 Залруулсан алдаа	11

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ХНХ	Хөдөлмөр нийгмийн хамгаалал
ЭХМК	Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс
ХХҮГ	Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/			
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	0.00	0.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.00	0.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	0.00	0.00
3121	Төгрөг	0.00	0.00
31213	Арилжааны банк дахь харилцах	0.00	0.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	0.00	0.00
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	24000.00	0.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	24000.00	0.00
413	Өглөг	24000.00	0.00
4136	Бусад өглөг	24000.00	0.00
41361	Байгууллагад төлөх өглөг	24000.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	-24000.00	0.00
51	Засгийн газрын хувь оролцоо	-24000.00	0.00
512	Хуримтлагдсан үр дүн	-24000.00	0.00
51210	Өмнөх үеийн үр дүн	521166.40	0.00
51220	Тайлант үеийн үр дүн	-545166.40	0.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	0.00	0.00

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	5758604427.31	377775250.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	57427.31	0.00
120	Нийтлэг татварын бус орлого	57427.31	0.00
120002	Хүүгийн орлого	57427.31	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5758547000.00	377775250.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	5603564000.00	166730250.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5603564000.00	166730250.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	154983000.00	211045000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	154983000.00	211045000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	5759149593.71	377775250.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5759149593.71	377775250.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5759149593.71	377775250.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	5680992243.00	275040880.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	5680992243.00	275040880.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	57757350.71	20589370.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	57757350.71	20589370.00

2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	20400000.00	82145000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	20400000.00	82145000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-545166.40	0.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-545166.40	0.00

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	5,769,668,280.31	377,775,250.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	11,121,280.31	-
120	Нийтлэг татварын бус орлого	11,121,280.31	-
120002	Хүүгийн орлого	57,427.31	-
120009	Бусад орлого	11,063,853.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,758,547,000.00	377,775,250.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	5,603,564,000.00	166,730,250.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5,603,564,000.00	166,730,250.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	154,983,000.00	211,045,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	154,983,000.00	211,045,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	5,770,213,446.71	377,775,250.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,770,213,446.71	377,775,250.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,770,213,446.71	377,775,250.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,692,056,096.00	275,040,880.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	5,692,056,096.00	275,040,880.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	78,157,350.71	102,734,370.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	78,157,350.71	102,734,370.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(545,166.40)	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(545,166.40)	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	545,166.40	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			-24,000.00	-24,000.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	-24,000.00	-24,000.00
C07	Тайлант үеийн үр дүн			24,000.00	24,000.00
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
D01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00		0.00
D08	Тайлант үеийн үр дүн			0.00	0.00
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	377,775,250.00	286,162,160.31
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	166,730,250.00	146,140,880.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	166,730,250.00	146,140,880.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	211,045,000.00	128,900,000.00
132001	Орон нутгийн төсвөөс	211,045,000.00	128,900,000.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	8.00	8.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	7.00	7.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	8.00	8.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	8.00	8.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Халамжийн сан нь "Нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот өрх, иргэдэд түргэн шуурхай чирэгдэлгүй хүргэх, нийгмийн халамжийн үйлчилгээг чанартай, үр дүнтэй, шуурхай

хүргэх замаар нийгмийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэгдсэн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний төрийн бодлогыг орон нутагт хэрэгжүүлэн ажиллахад оршино.” гэж тодорхойлжээ. Үүнд:

- Нутаг дэвсгэртээ хууль тогтоомжийг хэрэгжүүлэх
- Засгийн газрын шийдвэр харьяалах дээд шатны шийдвэрийг гүйцэтгэлийг хянах
- Харьяа яамны сайдын тушаал, шийдвэрийг хэрэгжүүлэх
- Нийгмийн халамжийн тэтгэвэр
- Нийгмийн халамжийн тэтгэмж
- Нийгмийн халамжийн үйлчилгээ
- Нийгмийн хөгжлийн үйлчилгээ

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн халамжийн багц хуулиудын өөрчлөлт
- Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын өөрчлөлт
- Засгийн газрын 2018 оны 31 дүгээр тогтоолын өөрчлөлт мөрдөн ажиллаж байна

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт **үр нөлөөтэй** байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторгаас шууд туслалцаа авах **шаардлагагүй** гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Халамжийн сангийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газрын хяналт шинжилгээ үнэлгээний хэлтсээс хяналт хийгдээгүй байна.

Харин ХХҮГ-ын захиргаа хяналтын хэлтэс дотоод хяналтаа хэрэгжүүлсэн хэдий ч Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан ХХҮЕГ-ын даргын 2020 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн тушаалаар батлагдсан А/58 тоот аргачлалын дагуу үзүүлэх “Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ”-ний үр дүн бага түүнд хариуцсан хэлтсийн зүгээс тавих хяналт хангалтгүй газрын дотоодын хяналт сул байна.

Байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд ДУНД гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналтгүй гэж үзлээ

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Халамжийн сангийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны орон нутгийн төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 211.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 166.7 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 211.0 сая төгрөг нийт 377.7 сая төгрөгийн санхүүжилт авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 275.0 сая төгрөгийг нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж хөнгөлөлтөд зарцуулж, 20.6 сая төгрөгийг улсын төсөвт, 82.1 сая төгрөгийг орон нутгийн төсөвт тус тус төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Д/д	Хөтөлбөр арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	71902/80708 – НХ-н тэтгэвэр тэтгэмж	91.0	79.7	11.3	87.5%
2	71902/80709 – НХ-н тэтгэвэр тэтгэмж	120.0	49.2	70.8	41%
	Нийт дүн	211.0	128.9	82.1	

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тухайн тайлангийн жилд нэмэлтээр орлого, зарлагын гүйлгээ гараагүй болно.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөр байхгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Халамжийн сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аудитор Ц.Гантулга 2023 оны 01 дүгээр сарын 27-ноос 02 дугаар сарын 01-ний хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 33 албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлын 377.7 сая төгрөгөөс 1 хувиар буюу 3.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 3.0 сая төгрөгөөр тогтоосон. Материаллаг байдлын дүн буурахад халамжийн сангийн санхүүжилтийг дээд шатны байгууллагаас олгодог болсонтой холбоотой нийт зардлын дүн буурсан нь нөлөөлсөн болно.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

Засгийн газрын тусгай сан учраас тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламжаас өөр зардалд зарцуулдаггүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг

тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 167 мэдээллээс хугацаандаа оруулсан 159 мэдээлэл, хугацаа хоцроосон мэдээлэл 8 байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

2022 онд завсрын аудит хийгээгүй, өмнөх оны зөвлөмжийн хэрэгжилтийг хянасан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгөгдсөн ТББ сургалтын гэрээгээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэнтэй холбоотой 0.6 сая төгрөгийн төлбөрийн акт, амралтын эрхийн бичгийг харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж баталгаажуулаагүйтэй холбоотой 2.7 сая төгрөгийн зөвлөмж өгөгдсөн нь бүрэн хэрэгжүүлсэн байна.сэн болно.

Хүснэгт 3 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	570.0	1	570.0	100
Зөвлөмж	1	2690.0	1	2690.0	100
Нийт дүн	2	3260.0	2	3260.0	

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн зардалд анхаарах шаардлагатай гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 4.2 сая төгрөгийн алдаа¹ илэрсэнд алдааг дахин давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө

5.1 Залруулсан алдаа

Аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй

5.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй болно.

5.3 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага бичигдээгүй болно.

5.4 Зөвлөмж

5.4.1 Гэрийн асрамж халамжийн үйлчилгээтэй холбоотой асуудал.

Илрүүлэлт: Аймгийн Улаан загалмай нийгэмлэгтэй хийсэн гэрээгээр гэрийн асрамж халамжийн үйлчилгээ үзүүлсэн жолооч нарын замын хуудсыг нэгдсэн байдлаар бичигдсэн, тэдгээртэй хууль эрх зүйн үндэслэлгүй гэрээ байгуулж үйлчлүүлсэн зэрэг анхан шатны бүрдэл болоогүй баримтаар 4200.0 сая төгрөгийн зардал олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-д “анхан шатны баримт” гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог, 13 дугар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно.” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж ХХҮГазрын даргын 2020 оны 04 дугаар сарын 06-ны өдрийн А/58 тушаалаар баталсан “ Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдах иргэний тоо, шаардагдах хөрөнгийн хэмжээг тодорхойлох аргачлал”-ын холбогдох заалтыг мөрдөн ажиллах
Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Үүнээс							
	Нийт алдаа		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Гэрийн асрамж халамжийн үйлчилгээ үзүүлсэн жолооч нарын замын хуудсыг нэгдсэн байдлаар бичигдсэн, тэдгээртэй хууль эрх зүйн үндэслэлгүй гэрээ байгуулж үйлчлүүлсэн зэрэг анхан шатны бүрдэл болоогүй баримтаар зардал олгосон	1	4,200.0					1	4200.0
Дүн	1	4200.0	-	-	-	-	1	4200.0

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Х.БОЛДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР:  А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АУДИТОР:

Ц.ГАНТУЛГА